



**НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ
ЭЙРПОРТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар A/13

Улаанбаатар хот

**Зураг авалт хийх журам, хураамж
батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Үндэсний хөгжлийн газар болон “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн хооронд 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 2 дугаар хавсралт, Компанийн дүрмийн 13.4-ийн (е) заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд зураг авалт хийх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Зураг авалтын хураамж”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд зураг авалт хийх журам”, “Зураг авалтын хураамж”-ийг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү хариуцсан захирал бөгөөд Захиргаа, удирдлагын газрын дарга /Кишикава Норико/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



КАТО ТАКЭО



“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 09 дугаар сарын 11-ны өдрийн А/В... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Нисэх буудалд зураг авалт хийх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Чингис хаан” Олон улсын нисэх буудал (цаашид “ЧХОУНБ” гэх) дахь Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК (цаашид “НУБИЭ ХХК” гэх) -ийн хариуцсан хэсгийн гадна болон дотор зураг авалт хийх, төлбөр хураамж авахтай холбогдуулан НУБИЭ ХХК болон аж ахуйн нэгж, иргэнтэй үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын (цаашид “Журам” гэх) зорилго оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. НУБИЭ ХХК нь аж ахуйн нэгж, иргэний бичгээр гаргасан хүсэлт, нисэх буудлын талбайд нэвтрэх зөвшөөрөл болон Журамд үндэслэн зураг авалт хийх зөвшөөрөл олгоно.

2.2. НУБИЭ ХХК нь аж ахуйн нэгж, иргэний зураг авалт хийх зөвшөөрөл хүсэх Өргөдлийн маягтыг үндэслэн зураг авалтын хугацааг тогтоон зөвшөөрөл олгоно. Зөвшөөрлийн хугацаа 1 (нэг) сараас дээшгүй байна.

2.3. НУБИЭ ХХК-ийн Гүйцэтгэх захирал нь зураг авалтын хураамжийг тушаалаар батална.

2.4. Зөвшөөрлийг зөвхөн олгосон зориулалтаар ашиглана.

Гурав. Зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, зураг авалтыг цуцлах болон төлбөр тооцоо

3.1. Аж ахуйн нэгж, иргэн нь ЧХОУНБ-ын НУБИЭ ХХК-ийн хариуцсан хэсгийн гадна болон дотор талд зураг авалт хийх хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд дараах материалыг хавсаргана:

- 3.1.1. Өргөдлийн маягт;
- 3.1.2. Зураг авалт хийх эскиз (загвар) зураг;
- 3.1.3. Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар);
- 3.1.4. Нисэх буудлын барилга байгууламжид нэвтрэх зөвшөөрөл.

3.2. Нислэгийн талбай болон нэвтрэх хориотой бүсэд зураг авалт хийхийг хориглоно. Нислэгийн талбай болон нэвтрэх хориотой бүсэд зураг авалт хийх хүсэлт гаргасан тохиолдолд уг зураг авалт хийх хүсэлтийг үндэслэн зөвхөн НУБИЭ ХХК-ийн тусгайлан олгосон зөвшөөрлийг авсан тохиолдолд зөвшөөрнө.

3.3. Зураг авалтын явцад НУБИЭ ХХК-ийн Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар болон Төлөвлөлтийн хэлтсийн ажилтнууд хяналт тавих зорилгоор хамт байлцана. Өргөдлийн маягтыг зураг авалт эхлэхээс ажлын 10 (арав) хоногийн өмнө ирүүлэх шаардлагатай бөгөөд НУБИЭ ХХК нь хүсэлтийг ажлын 5 (тав) хоногийн дотор шийдвэрлэнэ.

3.4. Журмын 3.2-т заасан зөвшөөрөл олгосноос хойш Аж ахуйн нэгж, иргэн нь ажлын 3 (гурав) хоногийн дотор зураг авалтын төлбөр тооцоог НУБИЭ ХХК-ийн дансанд шилжүүлнэ.

3.5. Аж ахуйн нэгж, иргэн нь зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас 3 (гурав) хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.

3.6. НУБИЭ ХХК нь зөвшөөрөл сунгах эсэхийг Журмыг үндэслэн шийдвэрлэнэ.

3.7. Зөвшөөрөл олгосон болон хугацаа сунгах зөвшөөрөл гарснаас хойш ажлын 3 (гурав) хоногийн дотор төлбөрөө төлөөгүй тохиолдолд НУБИЭ ХХК нь зөвшөөрлийг цуцалж болно.

3.8. Зураг авалтыг НУБИЭ ХХК-иас тогтоосон хугацаанд буюу Даваа гарагаас Баасан гарагийн 08:00-17:00 цагийн хооронд, зөвхөн зөвшөөрөгдсөн талбайд хийнэ. Тогтоосон хугацаанд зураг авалтыг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хийх боломжгүй тохиолдолд НУБИЭ ХХК нь тухайн шалтгааныг үндэслэн зөвшөөрөл олгож болно.

3.9. НУБИЭ ХХК нь аж ахуйн нэгж, иргэнийг Журмын заалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд зураг авалтыг шууд зогсоох, талбайгаас албадан гаргах зэрэг арга хэмжээ авах эрхтэй.

Дөрөв. Аж ахуйн нэгж, иргэний эрх, үүрэг

4.1. Зураг авалт хийх зөвшөөрлийн хугацаанд зөвшөөрөгдсөн талбайд зураг авалт хийх, зураг авалт хийх талбайн бэлтгэл хангуулах талаар НУБИЭ ХХК-д хүсэлт гаргаж болно.

4.2. Зөвшөөрлийн хугацаанд зураг авалт хийж амжаагүй бол зөвшөөрлийг сунгуулах хүсэлт гаргаж болно.

4.3. Энэхүү чиглэлээр байнгын хамтран ажилладаг бол (3 болон түүнээс дээш удаа) төлбөрөөс 10-50 хувь хүртэл хөнгөлүүлж болно.

4.4. Зөвшөөрөгдсөнөөс бусад талбайд нэвтрэх, зураг авалт хийхийг хориглоно. Мөн зорчигч, үйлчлүүлэгч, НУБИЭ ХХК-ийн ажилтан, агаарын тээвэрлэгч, төрийн байгууллагын ажилтнуудын ажилд саад учруулахыг хориглоно. Агаарын тээвэрлэгчээс урьдчилан зөвшөөрөл авалгүй агаарын хөлөг болон агаарын хөлгийн хэсэг, лого зэргийг зураг авалтын дүрс бичлэгт оруулахыг хориглоно.

4.5. Зураг авалтын талбайд НУБИЭ ХХК-ийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Мөн НУБИЭ ХХК-ийн хариуцсан барилга байгууламж, эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр хөдөлгөх, хүрэх, гэмтээхийг хориглоно.

4.6. Зөвшөөрөгдсөн талбайд өөрсдийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллах үүрэгтэй.

4.7. Зураг авалтын үед техникийн болон аюулгүй ажиллагааны журмыг зөрчсөнөөс бусдад учруулсан хохирлыг барагдуулах үүрэгтэй.

4.8. Хураамжийг Журамд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй.

4.9. Зураг авалтын хугацаанд НУБИЭ ХХК болон нисэх буудлын барилга байгууламж, нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой мэдсэн нууц мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

4.10. Хийсэн дүрс бичлэгээ олон нийтэд цацахаас өмнө НУБИЭ ХХК-д шалгуулж, зөвшөөрөл авах шаардлагатай.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Журмыг зөрчсөн гэм буруутай аж ахуйн нэгж, иргэнд Монгол Улсын Иргэний тухай хууль, Байгууллагын болон Хувь хүний нууцын тухай Монгол Улсын хууль, Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

5.2. Журам, холбогдох хууль, тогтоомж, дүрэм зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн барагдуулна.



“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2020 оны 19 дугаар сарын 14 ны
өдрийн 1/13..... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Зураг авалтын хураамж

(НӨАТ ороогүй дүн ₮)

Байрлал	Хугацаа	Өдөр 08:00-17:00	Шөнө 17:00-08:00
Перрон болон бусад талбайд “Перрон талбайд зураг авалт хийх тусгайлан олгосон зөвшөөрөлтэй байх”	1 /нэг/ цаг	420,000.00	500,000.00